

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### 1/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3. Энэ хуулийн 10.1, 10.2-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашиглахыг хориглоно.”

#### 2/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

“14.3. Энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас баталсан онооны аргачлалын дагуу тогтооно.”

**2 дугаар зүйл.** Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.2. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана.”

**3 дугаар зүйл.** Зээлийн мэдээллийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг “зургаан” гэснийг “зургаа хүртэлх” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох онооны аргачлал болон зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд зургаа хүртэлх жилээр тусгах нөхцөл, шалгуурыг дараах нөхцөлийг харгалзан батлахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай:

1/иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн ангилал давагдашгүй хүчин зүйлээс хамаарч хэвийн ангиллаас бусад ангилалд орсон бөгөөд зээлийн өр, төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд, түүнчлэн бусад нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох;

2/иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн төрөл, зээлийн өр, төлбөрийг бүрэн төлж барагдуулсан хугацаанаас хамаарч зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох;

3/энэ тогтоолын 1 дэх заалтын 1, 2 дахь дэд заалтад төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагын дэргэдэх сангаас болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлээ хугацаандаа төлөөгүй, түүнчлэн хэвийн зээлийн ангиллаас бусад ангилалд орсон иргэн, аж ахуйн нэгж, түүний зээлийн мэдээллийг хамаарулахгүй байх.

2.Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох онооны аргачлалыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-д тус тус даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг